

## **ТӨВ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2020 ОНЫ 02 ДУГААР САРД ХИЙСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ**

2020 оны 02 дугаар сарын 28

Зуунмод

Төв аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын хэмжээнд 2020 оны 02 дугаар сард хийсэн ажлын мэдээллийг танилцуулж байна.

### **Нэг. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба:**

Аймгийн ИТХ-ын ээлжит 16 дугаар хуралдаан 2020 оны 2 дугаар сарын 13-ны өдөр хуралдаж 3 асуудал хэлэлцэн холбогдох шийдвэрүүдийг гаргалаа. Үүнд:

1. “Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн тайлан, мэдээлэл, түүнд Хурлын Хороодоос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд ажлын ололт амжилт, үр дүнг улам бататгаж, эрчимжүүлэх шаардлагатай гэж үзэн хөтөлбөрт дэвшүүлсэн 112 зорилт, 378 арга хэмжээний хэрэгжилтийн явц 94.28 хувийн гүйцэтгэлтэй тул “ҮР ДҮНТЭЙ” гэж дүгнэв.

2. Аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлтийн тухай тайлан, мэдээлэл, түүнд хурлын Хороодоос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд 93.93 хувийн биелэлттэй байх тул “ҮР ДҮНТЭЙ” гэж дүгнэв.

3. Газрын харилцааны талаар 2019 онд хийсэн ажлын чиглэлийн хэрэгжилтийг 90.45 хувийн биелэлттэй байх тул “Үр дүнтэй” гэж дүгнэв. Мөн “Аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг 2020-2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г баталлаа.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн II хуралдааныг 2 дугаар сарын 06-ны өдөр, ээлжит бус I хуралдааныг 02 дугаар сарын 12-нд, III хуралдааныг 02 дугаар сарын 20-ны өдөр тус тус хуралдаж, нийт 23 асуудлуудыг хэлэлцлээ. Үүнээс заримыг дурьдвал:

1. Аймгийн “Хөдөлмөрч манлай ахмад”-аар 9 ахмадыг шалгаруулсан.

2. Аймгийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцээд 95.2 хувиар хэрэгжсэн тул “Бүрэн хэрэгжсэн” гэж дүгнэн “Аймгийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны 2020 оны төлөвлөгөө”-г батлав.

3. “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн 2020-2023 оны дэд хөтөлбөрийг батлав.

4. “Хөрөнгө шийдвэрлэх тухай” асуудлыг хэлэлцээд аймгийн Нэгдсэн эмнэлэг, Цагдаагийн газар, Мөнгөнморьт, Баянжаргалан, Баянхангай, Лүн сумдын Засаг даргын Тамгын газрын автомашиныг дуудлага худалдаагаар худалдах доод үнэ, Мөнгөнморьт сумын Эрүүл мэндийн төвийн актлах барилга, Актлах тавилга, тоног төхөөрөмж, Балансаас балансад шилжүүлэх тоног төхөөрөмжийг тус тус акталж шийдвэрлэв.

5. Захиргааны шийдвэр, захиргааны хэм хэмжээний акт гаргах, хяналт тавих журмыг батлав.

6. Зуунмод сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийг Монгол Улсын гавьяат багш, клиникийн профессор Ч.Доржгочоогийн нэрэмжит болгов.

7. Заамар сумын зарим газар нутгийг бичил уурхайн зориулалтаар аймгийн тусгай хэрэгцээнд авахуулах асуудлыг дахин хэлэлцээд энэ оны 6 дугаар сард хуралдах аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын арван долдугаар хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг даргад даалгалаа.

8. Соёл, урлагийн байгууллагуудын орлогыг үнэт цаасаар тооцох журам батлав.

9. Аймгийн нөхөн сонгуулийн хороог татан буулгах тухай асуудлыг хэлэлцээд 2019 онд Жаргалант, Мөнгөнморьт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуулийг явуулахад мэргэжил арга зүйн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий аймгийн сонгуулийн хороог 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн татан буулгав.

10. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны сүүлийн хагас жилд хурлын тэмдэглэлээр өгсөн үүргийн хэрэгжилтийг хэлэлцээд хуралдааны тэмдэглэлээр үүрэг өгөв.

11. Ахуйн зориулалтаар 2020 онд агнах, барих ан амьтдын тоо хуваарийг батлав.

12. "Хог хаягдлыг бууруулах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах, экспортлох үйл ажиллагаа эрхэлдэг болон байгаль орчинд ээлтэй, хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам"-ыг батлав.

### **Хоёр. Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хүрээнд:**

**Нутгийн удирдлага, хамтын ажиллагааны хүрээнд:** Монгол Улсын Ерөнхий сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан "Батламж", Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргын аймгийн Засаг даргатай 2020 онд хамтран ажиллах гэрээний холбогдох заалтуудыг хяналтад авч Аймгийн ЗДТГ-ын даргын 2020.02.03-ны өдрийн 02/213 тоотор бодлогын хэлтэс, албанд хүргүүлэв.

"Хүртээмжтэй, чанартай төрийн үйлчилгээ" урианы жилийн цахимжуулалтын ажлыг эрчимжүүлэх зорилгоор аймгийн ЗДТГ-ын даргын 2020 оны А/07 дугаар тушаалаар дэд ажлын хэсэг байгуулан үүрэг чиглэл өглөө.

Цаг үеийн ажлыг шуурхай зохион байгуулах үүднээс 02 дугаар сарын 11-ний өдөр 27 сумын Засаг дарга, ЗДТГ-ын дарга, төсөвт 5 байгууллагын удирдах ажилтны бүрэлдэхүүнтэй нийт 160 гаруй албан хаагчидтай цахим хурал хийж, аймгийн Засаг даргаас үүрэг чиглэл өгөв.

"Засаг захиргааны анхан шатны нэгж багийн хөгжлийг дэмжих БАГ-97 төсөл"-ийн хүрээнд дэвшүүлсэн зарим зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор 2019 оны үйл ажиллагааны үр дүнг харгалзан аймгийн "Жишиг баг", "Тэргүүний баг"-ийн эхний шатны шалгаруулалтыг хийлээ.

Аймгийн ЗДТГ-ын бодлогын хэлтсүүдийн 2020 оны хагас жилийн төлөвлөгөө, ТЖАХ-чдын 1 дүгээр улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус батлав.

Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын зөвлөл 1 удаа хуралдаж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэх 3 асуудлыг хэлэлцэж, сайжруулалт хийн ИТХ-д өргөн барьсан.

2020 оны 02 дугаар сарын 28-ны байдлаар байдлаар Монгол улсын төрийн одон медалиар шагнуулахаар орон нутгаас ирүүлсэн 142 иргэний материалыг /Үүнээс ТАХ 25/ аймгийн Засаг даргын зөвлөлийн, дээд шатны байгууллагаас ирүүлсэн саналын дагуу 26 иргэний материалыг /Үүнээс ТАХ 4/ аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар тус тус хэлэлцүүлсэн.

**Төрийн албаны стандартын хүрээнд:** Төрийн албаны зөвлөлийн Төв аймаг дахь Салбар зөвлөлийн хуралдааныг зохион байгуулж, 2019 оны үйл ажиллагааны тайлан болон бусад асуудлыг хэлэлцүүлж, холбогдох шийдвэрийг гаргасан. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны тайланг товхимол болон видео хэлбэрээр бэлтгэн ТАЗ-д танилцуулсан.

Төрийн албаны нөөцийн бүртгэл мэдээллийг 4 байгууллагын хүсэлтээр хүргүүлж, Ахлах түшмэлийн сургалтад хамрагдах албан хаагчдын судалгааг гарган Удирдлагын академид хүргүүлэв.

Төрийн албан хаагчдын зэрэг дэвийн нэмэгдэл олгуулах саналыг хэлтэс, агентлаг, сумдаас авч, нягтан шалгаж Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлтгээд байна.

Аймгийн хэмжээнд Төрийн захиргааны албан тушаалын сул орон тооны захиалгыг шинэчилэн гаргав.

#### Сургалтын мэдээлэл:

№	Сургалт зохион байгуулсан хугацаа	Сургалтад хамрагдсан	
		Байгууллага, албан тушаалтан	ТАХ-ийн тоо
1	2020.01.09	Сумдын ЕБС, Цэцэрлэгийн эрхлэгч нарын нэгдсэн сургалтанд Салбар зөвлөлөөс 2020 онд баритмлах чиглэл, хүний нөөцийн системийн бүртгэлийн тухай	54
2	2020.01.10	Сумдын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, МЭҮТ-ийн мэргэжилтэн нарт зориулсан сургалт	41
3	2020.01.13	Мэдээлэл харилцаа, холбооны газартай цахим систем аймгийн хэмжээнд нэвтрүүлэхтэй холбогдон ERP системийн таинлцуулга сургалтанд хамрагдав	3
4	2020.01.22-23	Төрийн албаны Салбар зөвлөл, аймгийн ЗДТГ, МЕРИТ төсөлтэй хамтран “Багийн хамтын ажиллагаа хүчирхэг баг бүрдүүлэх нь” сэдэв сургалтыг сумын ЗДТГ-ын дарга, Бодлогын хэлтсийн болон зарим агентлагийн Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн нарт зориулсан гэрчилгээ олгох сургалт	35
5	2019.01.29-30	Сумдын ИТХ. Засаг дарга, ЗДТГ-ын дарга нарын нэгдсэн сургалт Төрийн албаны Салбар зөвлөлөөс 2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, анхаарах асуудлын талаар нэгдсэн чиглэл өгч ажиллав.	79
<b>НИЙТ ДҮН</b>		<b>8 байгууллага, нэгж</b>	<b>212</b>

Салбар зөвлөлөөс зохион байгуулж буй үйл ажиллагааны мэдээ мэдээллийг тухай бүр мэдээллийн самбар, ДУС, facebook болон [www.tov.gov.mn](http://www.tov.gov.mn) цахим хуудасны “ТАЗСЗ” цэсээр олон нийтэд сурталчилан танилцуулж байна. Мэдээ мэдээлэл байршуулсан байдал: /2020.02.28-ны байдлаар тоогоор/

№	Мэдээ мэдээллийн	
	Цэс	Тоо
1	Цаг үеийн мэдээ мэдээлэл	7
2	Тогтоол шийдвэр, Хуралдаан	4
3	Бүрэлдэхүүн	-
4	Нөөцөөс нөхөх зар	-
5	Төрийн албаны ерөнхий шалгалтын зар	9
6	Удирдах ажилтны сонгон шалгаруулалтын зар	1
<b>НИЙТ ДҮН</b>		<b>21</b>

2020 оны 02 дугаар сарын 28-ны байдлаар салбар зөвлөлд:

№	Төрөл	Нийт ирсэн	Үүнээс хариутай	Шийдвэр-лэсэн	Хүлээг-дэж буй	Шийдвэр-лэлтийн хувь
1	Албан бичиг	31	5	4	1	-
2	Өргөдөл, гомдол	3	2	1	1	-

**Гадаад харилцаа:** БНХАУ-ын Жилинь мужид шинэ төрлийн Коронавирусийн халдварын тохиолдол гарсантай холбогдуулан сэтгэлийн дэм үзүүлэх албан тоот хүргүүллээ.

БНСУ-ын Кёнги аймгийн Пёнтак хотын хөрөнгө оруулалтаар хийгдэх Номын сангийн засварын ажлын зураг төсвийн 50%-ийн санхүүжилтыг шилжүүлэн зураг төслийг хүлээн авч, Барилга хөгжлийн төвд хянауулахаар хүргүүлсэн. Мөн тус хотын захиргаатай хамтран ажиллах санамж бичгийн төслийг боловсруулж, Төв аймгийн Зуунмод суманд Сайн дурын ажилтан томилон ажиллуулах талаар санал солилцож байна.

**Төрийн үйлчилгээний нэгдсэн төв:** 2020 оны 2 дугаар сард Төрийн болон бизнесийн дэмжих үйлчилгээний нийт 23 байгууллага 300-аад төрлийн үйлчилгээг **4723** иргэнд, өдөрт дунджаар 300-350 иргэнд хүргэж байна. Аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж буй ажил үйлчилгээ, арга хэмжээний мэдээллийг “Өлзий”, TBS, Төв телевизүүд, аймгийн албан ёсны веб сайт, пейж хуудас, мэдээллийн болон урсдаг самбар зэрэг эх сурвалжаар иргэд, олон нийтэд түгээж байгаа бөгөөд 2 дугаар сард аймгийн веб сайтад **47**, “Төв аймгийн Хэвлэл мэдээллийн алба” пэйж хуудсанд **88** мэдээ мэдээлэл тус тус нийтлэгдлээ. Харин 7 хоног бүрийн Лхагва гаригт цацагддаг “Төв аймгийн цаг” нэвтрүүлгийн **3-н** дугаарт **5** мэдээ мэдээлэл бэлтгэн өгч, олон нийтэд хүргэсэн. Мөн бусад 7 төрлийн телевизүүдийн мэдээний цагаар **18** мэдээ мэдээлэл гарсан нь давтагдсан тоогоор **54** удаа цацагдсан байна. Төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой санал, гомдлыг хүлээн авдаг 7027-1111 нээлттэй утсанд **4** гомдол ирснийг холбогдох хэлтэс, агентлагуудад уламжилсан бөгөөд одоогийн байдлаар шийдвэрлэх шатандаа явж байна.

**Мэргэжлийн хяналтын газрын үйлчилгээ:** Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2020 оны 10 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 2020 оны 62 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 4 дүгээр хурлын тэмдэглэл, Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 08 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор газрын даргын 2020 оны А/08, А/10, А/11, А/12 дугаар тушаалаар өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлэн, 24 цагийн хариуцлагатай жижүүрийг томилж, албан хаагчдыг үүрэгжүүлэн ажиллаж байна.

**Соён гэгээрүүлэх ажлууд:** Шинэ төрлийн корона вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх 7 төрлийн сэрэмжлүүлэг, 15 төрлийн зөвлөмжийг байгууллагын цахим хуудас, олон нийтийн мэдээллийн сүлжээнд байршуулж, фейсбүүк хуудсаар дамжуулан олон нийтэд түгээсэн ба 223 иргэн, аж ахуйн байгууллагуудад цаасаар хүргүүлсэн. 176 иргэн аж ахуйн нэгж байгууллага буюу 78.9%-д гүйцэтгэлийн хяналт хийж, хэрэгжилтийг хангуулав. Мөн 12 удаагийн хяналт шалгалтын мэдээг түгээлээ.

**Төлөвлөгөөт бус шалгалт:** Эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий Зуунмод суманд үйл ажиллагаа явуулж байгаа 7 хувийн эмийн сангуудад “эмийн чанар, хүртээмж, нийлүүлэлт, жороор олголтын байдал”-д шалгалт хийхэд эмийн сангууд 360-1991 нэр төрлийн эмийн нөөцтэй, нөөцийн

хангалт 98%-тай, томуу томуу төст өвчний үед хэрэглэх 15-40 нэр төрлийн эм, антибиотикийн нөөцтэй, амны хаалт, гар ариутгагч уусмалуудын нөөц дутмаг байна.

**Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналт:** Мэргэжлийн хяналтын газар, прокурорын газрын даргын баталсан удирдамжийн дагуу Баян сумын Согтуурах Мансуурах донтой өвчтөнийг албадан эмчлэх албадан хөдөлмөр хийлгэх газарт эмчилгээ оношилгоо, эм био бэлдмэл, эрүүл ахуйн чиглэлээр шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчдын хамтарсан албан шаардлагаар хугацаатай үүрэг өгсөн.

Урандент ХХК-ийн ирүүлсэн хүсэлтийн дагуу тус эмнэлэгт лабораторитой шалгалт хийж гүйцэтгэлээ. Шалгалтын явцад тус эмнэлгийн 2 агаар, орчны эд юмс, багаж тоног төхөөрөмжөөс 20 арчдас, 2 усны дээж авч шинжлүүлэн, шинжилгээний дүнгийн тухай улсын байцаагчийн дүгнэлт үйлдсэн.

**Эмчилгээний чанарын хяналт:** Зуунмод сумын Номт багийн 18 дугаар байрны 38 тоотод “Бүх төрлийн эмчилгээний бариа, сэргээн засах эмчилгээ үйлчилгээ үзүүлнэ” гэсэн зарын дагуу урьдчилан сэргийлэх шалгалт хийхэд Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 3 дугаар хороо 5 дугаар хорооллын 20-11 тоотод оршин суугч О.Батбилэг иргэдэд уламжлалт сэргээн засах үйлчилгээ үзүүлж байсныг илрүүлж Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн 6.7 дугаар зүйлийн 1 дэх заалтаар хялбаршуулсан журмаар торгуулийн арга хэмжээ авч, танилцуулгыг албан бичгээр МХЕГ-т хугацаанд нь хүргүүлсэн.

**Газар, геодези зураг зүйн хяналт:** Зуунмод сумын Ланс 2 дугаар багийн нутаг дэвсгэрт Шатахуун түгээх станцын зориулалтаар үйл ажиллагаа явуулдаг Монсуль ХХК нь зөвшөөрөгдсөн газрын хэмжээнээс хэтрүүлэн газар ашигласан, Төв аймаг дахь Цагдаагийн газраас харъяаллын дагуу шилжиж ирсэн Батсүмбэр сумын Бардангийн энгэр гэх газар хууль бусаар оршуулгын зан үйл үйлдсэн гэх хэргүүдэд Зөрчлийн хэрэг нээн шалгаж Зөрчлийн тухай хуулийн 8.1 зүйлийн 10.2 дахь хэсэг заасны дагуу торгуулийн арга хэмжээ авч ажилласан.

**Геологи, уул уурхайн хяналт:** Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 19/06 дугаартай удирдамжийн дагуу Борнуур сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа 1 аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийж илэрсэн дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн хамтарсан хугацаатай албан шаардлага хүргүүлэв.

**Итгэмжлэгдсэн лаборатори:** Тайлант хугацаанд хяналт шалгалт, ААН, иргэний хүсэлтийн хүрээнд 81 сорьцыг хүлээн авч 178 үзүүлэлтээр сорилыг гүйцэтгэн үр дүнг баталгаажуулан хугацаа хэтрүүлэхгүй олгосон байна. Лабораторийн нийт 17 өрөө тасалгаанд жавельоны уусмалаар халдваргүйтгэл хийж, 12 нэр төрлийн 313 шил сав угаан ариутгаж шинжилгээний бэлэн байдлыг хангасан. 2 дугаар сарын байдлаар 1,299.300 төгрөгийн шинжилгээний орлогыг төрийн сангийн дансанд төвлөрүүлэв.

**Онцгой байдлын газрын хүрээнд:** Төв аймгийн хэмжээнд гамшгаас хамгаалах 3 албыг ажлын тусгай горимд шилжүүлэн бэлэн байдлыг хангуулан ажиллуулж байна.

Аймгийн Онцгой комиссын шийдвэрээр 02 дугаар сарын 18-ны өдрөөс Өндөр дов, Дөрөвдүгээр зөрлөгт 2 пост ажиллуулж, 02 сарын 28-аас 29-ний шилжих шөнө нийт 242 автомашин, 1139 хүний халууныг үзэж нэвтрүүлсэн. Сэжигтэй болон халуурсан хүн орон нутагт бүртгэгдээгүй байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/92 дугаар захирамжийн хүрээнд аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй баар, кафе, караоке, хүнсний дэлгүүр, супермаркетуудын үйл ажиллагааг 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөс 03

дугаар сарын 02-ны өдөр хүртэл үйлчлэх цагийн хуваарийг оройн 20.00 цаг байхаар тогтоосон.

**Гал түймэр:** 2020.02.01-нд Зуунмод сумын Ланс 2-р баг “ДЭНЖ”-ийн 11-р гудамж 12 тоот граж дотор сонато 6 /64-25 УНГ/ улсын дугаартай автомашин, 2020.02.09-нд Зуунмод сумын Зүүндэлгэр 4-р баг Төв замын дагуу байрлах хашаанд портер /67-57 ТӨВ/ улсын дугаартай автомашин, 2020.02.11-нд Зуунмод сумын Номт 1-р дүгээр баг МТ шатхуун түгээр станцны хажууд цахилгааны утас, 2020.02.21-нд Зуунмод сумын Зүүндэлгэр 4-р баг А14 гудамжны 8 тоотоод иргэн Батсуурийн хашаанд өвс, 2020.02.29-нд Зуунмод сумын Нацагдорж 5-р багийн “Ахмадын өдөр өнжүүлэх газар”-т уурын зуух тус тус шатсан дуудлагаар ажилласан.

### **Гурав. Хууль эрх зүйн хэлтсийн хүрээнд:**

“Захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт гаргах, хяналт тавих журам”-ыг боловсруулж, аймгийн ИТХТ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлууллаа.

ХЗДХЯ, ХЗС-тай хамтран Зууны мэдээ сонины 7 хоног тутмын “Хуульч зөвлөж байна” асуулт хариултын булан, Монголын радиогийн сар тутмын “Хуулийн цаг” зохиомжит нэвтрүүлгийн 02 сарын дугаарыг бэлтгэн нийтэд хүргэсэн.

Аймаг, сум, байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнуудын 52 шийдвэр, гэрээний хууль зүйн үндэслэлийг хянаж, эрх зүйн асуудлаар нийт 113 иргэн болон сумд, байгууллагуудад зөвлөгөө, мэдээлэл, лавлагаа, эрх зүйн туслалцаа үзүүлэв.

Аймгийн Захиргааны хэргийн шүүх, Иргэний хэргийн шүүхэд аймгийн Засаг даргыг төлөөлж 3 хэргийн хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож тайлбар дүгнэлт гаргаж, 2 шүүх хуралдаанд оролцож ажиллалаа.

Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах 238 албан тушаалтны 2019 оны шинэчилсэн мэдүүлгийг Авлигатай тэмцэх газрын цахим программд хуулийн хугацаанд бүрэн мэдүүлж, тайланг Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”, “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийн 2019 оны тайланг гарган холбогдох газруудад хүргүүллээ.

Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж, “Үндэсний аюулгүй байдлыг хангах 2020 оны нэгдсэн төлөвлөгөө”-г баталж, нутаг дэвсгэрт “Үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого”-ын төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулж, хурлын тэмдэглэлээр 27 сум, 30 байгууллагад 3 асуудлаар үүрэг чиглэл өгсөн. 2016 оноос 2020 оны 02 дугаар сарын байдлаар гадаад улсын 10 байгууллага, Засаг захиргааны 8 нэгж, Олон улсын 3 байгууллага, Төрийн бус 3 байгууллагатай “Хамтран ажиллах гэрээ”-7, “Хэлэлцээр”-1, “Санамж бичиг”-12, “Хамтарсан тунхаг бичиг”-3, “Хамтын ажиллагааны санал”-1, нийт 24 гэрээ, хэлэлцээр, санамж бичгийн жагсаалт болон аймгийн нутаг дэвсгэрт оршин суугаа БНХАУ-ын иргэдийн бүртгэл судалгааг нэгтгэн Үндэсний Аюулгүй Байдлын зөвлөлд хүргүүллээ.

“Төрийн болон албаны нууцын тухай хууль”, “Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”-д нийцүүлэн аймгийн Засаг даргын 2020 оны А/39 тоот захирамжаар аймгийн Засаг даргын Тамгын газрын “Нууц хамгаалах журам”-ыг шинэчлэн батлууллаа. Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах чиглэлээр Батсүмбэр суманд 8 үүрэг чиглэл өгөөд байна.

Аймгийн “Хүний эрхийн салбар хороо”-ны хурлыг зохион байгуулж 2019 оны ажлын тайланг хэлэлцүүлж, 2020 онд анхаарах асуудлаар салбар хороодын гишүүд болон сум, байгууллагад чиглэл өгч, 2020 оны нэгдсэн төлөвлөгөөг баталлаа.

“Нотариатын тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан 23 сумын нотариатын үүрэг хавсран гүйцэтгэгчийн нотариатын тамга, баталгааны тэмдгийг шинэчлэх ажлыг зохион байгуулж, сумдын төсвөөс 4.8 сая төгрөгийг зарцуулж хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулав.

**Архивын үйлчилгээ:** Төрийн архивын эх баримтаас 380 иргэний хүсэлтээр 1081 хуулбар хувь, 184 лавлагаа, 361 хөмрөгийн 1476 хадгаламжийн нэгж ашиглан лавлагаа мэдээллээр үйлчилж, 2.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт оруулсан.

2 хөмрөгийн 70 хадгаламжийн нэгжийн 5301 хуудас баримтын 20993 хүний нэр, 4768 заалтын тоо, 4768 тушаалын мэдээллийг програмд хадгаламжийн нэгжийн түвшинд шивж, скайнердаж, 2 хөмрөгийн 70 хадгаламжийн нэгжийн 4768 заалтын 5301 хуудас баримтыг өгөгдлийн сантай холбож цахим бааз үүсгэж, 2 хөмрөгийн 309 хадгаламжийн нэгжид эрдэм шинжилгээ техник боловсруулалтыг хийлээ.

**Улсын бүртгэлийн хэлтэс: Эд хөрөнгийн бүртгэл:** 2020 оны 02-р сарын байдлаар цахим санд нийт 54.246 хувийн хэрэг байгаагаас Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 9918, Газар өмчлөх эрхийн 44.328 байна. Нийт хүлээн авсан мэдүүлэг 15.035.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Засгийн газрын 2010 оны 237 дугаар тогтоолын дагуу үйлчилгээний хураамжийн орлогоос 30.4 сая төгрөгийг улсын төсөвт орууллаа.

**Хуулийн этгээдийн улсын бүртгэл:** Тайлант сард нэмэлт өөрчлөлтийн бүртгэлд 20 аж ахуй нэгж байгууллага бүртгүүлж, 33 хуулийн этгээд үүсэн байгуулагдсан. Тэмдэгтийн хураамжийн орлого 1.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт оруулсан.

**Цагдаагийн байгууллагын мэдээлэл:** Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд нийт 161 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 31 хэргээр буюу 19.3 хувиар өссөн.

-Хөнгөн гэмт хэрэг 133 бүртгэгдсэн нь 32 нэгжээр буюу 24 хувиар,

-Хэрэг бүртгэлтийн гэмт хэрэг 151 бүртгэгдэж 60 нэгжээр буюу 39.7 хувиар,

-Мөрдөн байцаалтын гэмт хэрэг 42 бүртгэгдэж 3 нэгжээр буюу 7.1 хувиар өссөн,

-Хүнд гэмт хэрэг 28 бүртгэгдэн өмнөх оны мөн үеийнхээс 1 нэгжээр буюу 3.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн илрүүлэлт 27.8 хувь байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.3 хувиар өссөн.

**Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байрны үйл ажиллагаа:** Эрүүлжүүлэгдсэн 44, баривчлагдсан 37, саатуулагдсан 13, нийт 94 хүнийг хүлээн авч, ар гэр асран хамгаалагчид 10 хүнийг хүлээлгэн өгсөн. Эрүүлжүүлэгдсэн 44 иргэн, хугацаа дуусч суллагдсан 40 иргэний нийт төлбөр 2.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт орууллаа.

**Олон нийтийн аюулгүй байдал:** Олон нийтийг хамарсан 8 удаагийн 45 цаг үргэлжилсэн арга хэмжээний хамгаалалтад 15 алба хаагч, 4 тээврийн хэрэгсэл, 30 тусгай хэрэгсэл, 4 станцтай 675 хүн/цагийн үүрэг гүйцэтгэж 1500 орчим иргэний аюулгүй байдлыг хангаж ажилласан. Гэмт хэрэг, хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр гудамж талбайд нийтийн эргүүл ажиллуулах тухай аймгийн Засаг даргын 2020 оны А/91 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 02 дугаар сарын 17-ны өдрөөс 03 дугаар сарын 02-ны өдрийг хүртэлх өдөр бүрийн 19:00-23:00 цагуудад нийт 31 байгууллагын албан хаагч нар батлагдсан хуваарийн дагуу эргүүл хийж байна.

**Хөдөлгөөний аюулгүй байдал:** Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож хөдөлгөөнд оролцсон 72 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилээр хасаж, 11 иргэнийг сум дундын шүүхээр баривчлуулж, Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, холбогдох хууль тогтоомж зөрчсөн нийт 5427 жолоочийг 159.325.000 төгрөгөөр торгосон.

**Шүүхийн шинжилгээний чиглэлээр:** Криминалистикийн шинжилгээ-36, Магадлан шинжилгээ-26, Хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн ул мөр-95, гарын мөрийн санг баяжуулсан-37, гэмтлийн зэрэг тогтоох үзлэгийн дүгнэлт 127 гаргасан.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн чиглэлээр:**

Шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт	Оны эхний үлдэгдэл	Шинээр нэмэгдсэн	Хасагдсан	Биелүүлбэл зохих	Бодитой биелүүлсэн	Үлдэгдэл	Дундаж хувь
02-р сар	321	106	11	416	97	319	23.3%
	4335533.1	690419.7	129942.4	4896010.4	384349.5	4511660.9	

**Дөрөв. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн хүрээнд**

**Хөрөнгө оруулалт, барилга хот байгуулалтын үйлчилгээ:** 2020 оны аймгийн ТЕЗ-н худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаас дараах хөрөнгө оруулалтын ажлуудын тендер шалгаруулалтыг эхлүүлсэн. Үүнд:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд: Үнэлгээний хороо байгуулсан 8 төсөл, арга хэмжээнээс 6,816.9 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээний тендерийг зарлаж, 6,744.6 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг боловсруулсан.
2. Аймгийн ОНХСангийн хөрөнгөөр 1,772.0 сая төгрөгийн 8 ажлын үнэлгээний хороог байгуулж тендерийг зарласан.
3. Аймгийн Замын сангийн хөрөнгөөр 273.0 сая төгрөгийн 6 ажлын үнэлгээний хороог байгуулж тендерийг зарласан.
4. Аймгийн БХНСАХСангаас хэрэгжүүлэхээр 5 ажлын үнэлгээний хороог байгуулж 204.3 сая төгрөгийн 3 ажлын тендерийг зарлаж 148.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийн боловсруулж тендерийг зарлахад бэлэн болгосон байна.
5. Аймгийн төсвийн шилжих үлдэгдлээс хэрэгжүүлэх ажлуудаас нийт 10 ажилд үнэлгээний хороог байгуулж 1,457.5 сая төгрөгийн 3 ажлын ТББичгийн боловсруулж, 905.3 сая төгрөгийн 5 ажлын тендерийг зарласан. 76.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээний гэрээг байгуулах шатандаа захиалагч байгууллагад мэдэгдэлийг хүргүүлээд байна.

“Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сан”-д Зуунмод сумын 450 барилга байгууламжийн мэдээллийг бүртгэн орууллаа.

2-р сард архитектур төлөвлөлтийн 9 даалгавар боловсруулснаар нийт 19 даалгавар баталлаа. Үүнд:

- Борнуур суманд “Горгаз”ХХК-ны олон төрөлт шатахуун түгээх станц
- Борнуур сумын соёл, спортын төвийн барилга, 30,0x33,0м
- Мөнгөнморьт сумын 75 ортой дотуур байрны барилга, 33,0x12,0м
- Сэргэлэн сумын соёл, спортын төвийн барилга, 42,75x24,25м
- Баянжаргалан сумын соёл, спортын төвийн барилга, 42,75x24,25м
- Эрдэнэсант суманд “Дашваанжил” ХХК-ны авто болон ахуйн баллон хийгээр цэнэглэх станц
- Заамар сумын сургуулийн өргөтгөлийн барилга, 42,4x34,4м



- Баянхангай сумын сургуулийн 50 ортой дотуур байрны барилга, 25,0x15,0м
- Архуст сумын сургуулийн 40 ортой дотуур байрны барилга, 18,0x15,0м

2-р сард 6 барилгын эх загвар, ажлын зураг төслийг хянаснаар нийт 9 зураг төсөл хянаад байна. Үүнд:

- Өндөрширээт сумын 10 ортой эмнэлэгийн барилга
- Баян-Чандмань сумын соёлын төвийн барилга
- Сэргэлэн сумын 1-р багт, “Лузерн эм кэй”ХХК-ны үйлдвэрийн цогцолбор барилга /Офисс, Үйлдвэрийн барилга, Агуулахын барилга/
- Сэргэлэн сумын 4-р баг, Баруун дэлгэрийн аманд Монголын Хөл бөмбөгийн холбооны Үндэсний шигшээ багийн бэлтгэлийн баазын дотуур байрны барилга
- Зуунмод сумын Зүүндэлгэр 4-р багийн гэр хорооллыг дулаан хангамж, цэвэр усан хангамжийн шугам сүлжээнд холбох ажлын зураг
- Зуунмод сумын Баруун Зуунмод 6-р багийн гэр хорооллыг дулаан хангамж, цэвэр усан хангамжийн шугам сүлжээнд холбох ажлын зураг

Барилга эхлүүлэх 2 зөвшөөрл олгож, 4 барилга байгууламжийн комисст ажиллав.

**ХАА-н чиглэлээр: Газар тариалангийн хүрээнд:** Аймгийн хэмжээнд зооринд хадгалагдаж байгаа төмс, хүнсний ногооны судалгаа авахад төмс 31901 тн, шар лууван 1301 тн, шар манжин 536,1 тн, сонгино 288 тн, байцаа 453,8 тн, бусад ногоо 69 тн тус тус борлуулагдаагүй байна.

Буудайн урамшуулалд хамрагдах 11 сумын 101 аж ахуйн нэгж, иргэний 2019 оны тариалалт, ургацын мэдээ, эргэлтийн талбай, байршилийн талаарх судалгаа болон 2020 оны хаврын тариалалтад шаардагдах үрийн захиалгыг 13 сумаас авч, буудайн 6282 тн, арвайн 302 тн, овъёосны 551 тн, бусад үр тарианы 751 тн дутагдаж байгаа тул үрийн захиалгыг ХХААХҮЯ-нд хүргүүллээ.

**Мал аж ахуйн хүрээнд:** Улсын аварга малчинаар манай аймгаас 9 малчин, 1 фермер шалгарлаа. Аймгийн аварга малчин шалгаруулах болзол журмын дагуу:

-Аймгийн хошой аварга малчнаар: 3 сумын 3 малчин

-Аймгийн аварга малчнаар: 26 сумын 54 малчин

-Ж.Самбуугийн нэрэмжит шагналт залуу малчнаар: 16 сумын 20 залуу малчин

-Аймгийн аварга фермерээр: 3 сумын 3 фермер

-Аймгийн алтан төлийн эзнээр: 7 сумын 9 малчин

-Аймгийн аварга саальчинаар: 4 сумын 4 саальчин

-Аймгийн аварга хадланчаар -1 сумын 1 хадланч тус тус шалгарлаа.

2019 оны жилийн эцсийн арьс ширний урамшуулалд 25 сумын 3999 малчны материалыг программд оруулж, падаан тулгалт, материал хүлээн авах ажил хийхэд нийт 286200 ширхэг арьс, шир үндэсний боловсруулах үйлдвэрт тушаасан байна.

**Үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээнд:** Хүнс, жижиг дунд үйлдвэрийн салбарт 2019 онд хийгдсэн онцлох 8 ажлыг видео болон танилцуулга хэлбэрээр бэлтгэн ХХААХҮЯ-ам болон иргэд, олон нийтэд тайлагналаа.

“Эрүүл хүнс-Эрүүл монгол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөрийг 5 зорилт 32 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр боловсруулан, аймгийн ИТХТ-ийн 2020.02.06-ны өдрийн 10 дугаар тогтоолоор батлуулав.

Сум хөгжүүлэх сангийн 2019 оны жилийн эцсийн тайланг “Бүртгэл, хяналтын нэгдсэн цахим программ”-аар 27 сум тайлагнаж, 8.3 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэл, 944.3 сая төгрөг дансны үлдэгдэлтэй, нийт 9.2 тэрбум төгрөгийн эргэлтийн сантай байна.

ХХААХҮЯамтай хамтран ЖДҮХСангаас 2016-2018 онд хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг авсан Борнуур, Жаргалант, Баянчандмань, Сэргэлэн сумын 12 төслийн үйл ажиллагаанд мониторинг хийж, эргэн төлөлтийг сайжруулах үүрэг чиглэл өглөө.

Аймгийн хүн амын гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээ, хангалт, нөөцийн судалгаа гарган цаг үеийн мэдээллийг аймгийн Онцгой байдлын комисст тухай бүр өгч байна.

**Мал эмнэлгийн үйлчилгээ:** Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1803.6 мян/мал хамруулахаар Биокомбинат УТҮГ-тай гэрээ байгуулж, вакцины нийлүүлэлт 30%-тай байна. Мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх 85 аж ахуй нэгжтэй гурвалсан гэрээ байгуулсан.

Нийгмийн хариуцлагын хүрээнд Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Мэргэжлийн хяналтын газар, Шүүхийн шинжилгээний албанд нийт 2,3 сая төгрөгийн ХХХ, ариутгалын бодис олгов.

Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор МХГ-тай хамтран эрүүл ахуй ариун цэврийн үзлэгийг 126 ААН, 58 иргэнд, зөвлөмж сэрэмжлүүлгийг 103 ААН, 575 иргэнд өгч, үхрийн Ферм-3, гахайн Ферм-4, шувууны Ферм-2, түүхий эдийн цэг-2 нийт 2400 м<sup>2</sup> талбайд ариутгал халдваргүйтгэл хийж, 3299 гэрчилгээ олголоо.

Зүй бус хорогдлын мэдээгээр 657 мал хорогдсоноос халдваргүй өвчнөөр 480 мал хорогдсон байна.

02 дугаар сарын 28-ны байдлаар 17 суманд мал төллөлт эхлэж 0,21%-тай байна.

Хаваржилт, төл бойжилтод шаардагдах эм биобэлдмэлийн нөөцөд:- Биовитен-423 кг, Бадглимецин-32 кг, Е Селин-14,4 л, Окситецин-18 л, Тетрациклин, Пенстрип, Аламицин-ЛА-85 л, Витамины комплекс-23 л, Комбивет-23 л, Кальцийн бэлдмэл 85 кг, натри 0.9, глюкоз, рингер-344 л, Суперкилл-96 кг, hisop-39 кг, хлорын шохой-46 кг тус тус байна.

Сургууль, цэцэрлэг, эмнэлэгт сүү нийлүүлдэг Батсүмбэр, Борнуур, Сэргэлэн, Зуунмод сумын саалийн 50 үнээний цусны дээжинд бруцеллёзын шинжилгээ хийхэд сөрөг дүнтэй гарлаа. Мөн Лүн, Эрдэнэсант сумаас ирсэн цус болон эд эрхтний 10 дээжинд цусан халдвар, дотрын халдварт хордлого өвчний шинжилгээ, 20 махны дээжинд шинэлэг байдал, антибиотикийн үлдэгдэл тодорхойлох шинжилгээ, 10 сүүний дээжинд сүүний чанар, бруцеллёзын шинжилгээ, 15 адуунд нийлүүлгийн өвчний шинжилгээг хийхэд сөрөг дүнтэй гарсан.

**Газрын харилцааны үйлчилгээ:** 2019 онд газрын харилцааны чиглэлээр хийсэн ажлын тайлан, 2020-2023 оны ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын 16 дугаар хуралдаанаар батлууллаа.

Газрын татвар, төлбөрийн системд 2018 оны илүү дутуу төлөлт, 2019 оны төлөлтийг 27 сумын 14225 эзэмшигч, ашиглагч бүрээр ногдуулалт үүсгэн программд оруулж, 1621 алдаатай мэдээллийг зассан.

2020 онд газрын төлбөрийн орлого 2900 сая төгрөг төвлөрүүлэхээс 2-р сарын 28-ны байдлаар 286,4 сая төгрөгийг төвлөрүүлээд байна.

Цээл сумын 9 байршил, Алтанбулаг сумын 16 байршилд газар эзэмших эрхийн дуудлага худалдааг зохион байгуулахаар **газрын цахим биржид** зар мэдээллийг байршуулан зарлалаа.

Цахим системд 27 сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний 8391 нэгж талбарыг оруулж, 2000 гаруй нэгж талбарын кадастрын болон давхцалыг арилган, алдааг засварласан.

**Байгаль орчны чиглэлээр:** Аймгийн ИТХТ-ийн 2020 оны 18 дугаар тогтоолоор аймгийн хэмжээнд 2020 онд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барих агнуурын амьтдын тоо, хуваарь батлуулан холбогдох сумдад хүргүүлээд байна. Энэ онд аймгийн хэмжээнд Аргаль хонь 10 толгой, Халиун буга 9, Цагаан зээр 20, Зэрлэг гахай 16, загас барих зөвшөөрөл 200 ширхэгийг олгоно.

Төв аймгийн Баянцогт сумын Сарлаг 2 дугаар багийн нутаг Эрдэнэтогтох уулын ар шилд зөвшөөрөлгүйгээр иргэд гар аргаар ашигт малтмал олборлож байсан үйлдэлд аймгийн Цагдаагийн газар, БОАЖГ, МХГ, Баянцогт сумын ИТХ-ын дарга, Засаг дарга, Багийн Засаг дарга, байгаль хамгаалагч нарын бүрэлдэхүүнтэй хяналт шалгалт хийж хууль бус үйлдлийг таслан зогсоож хөндөгдсөн 700 м<sup>2</sup> талбайд 2-2,5 м орчим гүн 76 нүх, шурф ухсан байсныг дарж булуулан техникийн нөхөн сэргээлт хийлгэлээ.

Хог хаягдлын менежментийг сайжруулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журмыг боловсруулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 19 дүгээр тогтоолоор батлуулав.

**Орон нутгийн өмчийн чиглэлээр:** Орон нутгийн өмчит байгууллагуудын 2019 жилийн эцсийн санхүүгийн тайлан, статистик мэдээг хүлээн авч 15 сумын 108 байгууллагын мэдээ тайланг нэгтгэлээ.

“Зуунмод мах боловсруулах үйлдвэр” ОНӨААТҮГазрын “Удирдлагын гэрээ”-г дүгнэх ажлыг эхлүүлсэн.

Сумын болон албан байгууллагуудаас ирсэн санлын дагуу жагсаалт гарган Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 11 дүгээр тогтоолоор 22 авто машиныг дуудлага худалдаагаар, Мөнгөнморьт сумын ЭМТ-ийн Моорогийн барилгыг актлаж устгахаар, Төрийн 6 байгууллагын 722 нэр төрлийн тавилга, тоног төхөөрөмжийг актлахаар, БТСГ-аас чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмжийг Батсүмбэр сумын ЕБС-д шилжүүлэхээр боллоо.

Аймгийн “Түрээсийн орон сууцны сан бүрдүүлж, зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-ын хүрээнд 2018 оноос хойш нийт 156 өргөдөл ирүүлснээс түрээсийн орон сууцад 25 өрхийг хамрууллаа.

**Стандарт хэмжил зүйн үйлчилгээ:** 2020 оны 02 сард Зуунмод, Алтанбулаг, Баянцагаан, Бүрэн, Дэлгэрхаан, Баян-Өнжүүл, Өндөрширээт суманд Тохирлын гэрчилгээ шинээр авах буюу сунгуулахаар хүсэлт ирүүлсэн 60 бүтээгдэхүүн үйлчилгээг үнэлгээнд хамруулж Баталгаажуулалтын зөвлөлийн 02 дугаар хуралдааныг хэлэлцүүлж, 20 үйлчилгээ, бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ хэрэглэх эрхийг 1-2 жилийн хугацаагаар олгохоор шийдвэрлэсэн. Нийт 63 бүтээгдэхүүн үйлчилгээнд тохирлын гэрчилгээ олгосон байна.

Хэмжилзүйн лабораторийн массын лаборатори нь: Төв аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмчилгээ оношлогоондоо ашиглаж байгаа массын 24 ш, Зуунмод, Баянцагаан сумын худалдаа үйлчилгээний мөнгөн тооцоонд ашиглаж байгаа нийт 31 ш, “Андууд” худалдааны төв, “Баянхаан” махны захын 19 ш жин болон туухайг холбогдох стандартын дагуу шалгаж баталгаажуулсан. Нийт 74 ш массын хэмжих хэрэгсэл баталгаажуулаад байна.

Эзэлхүүн зарцуулалтын лаборатори нь: Эрдэнэсант, Лүн, Баянхангай сумдад ажиллаж байгаа ШТС-ын хэмжих хэрэгслүүдэд улсын ээлжит баталгаажуулалтыг хийснээр нийт 11 ш хэмжих хэрэгсэл баталгаажуулав.

### **Тав. Нийгмийн бодлогын хэлтсийн хүрээнд:**

Аймгийн Засаг даргын зөвлөл, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар “Хөдөлмөрч манлай ахмад”-ын шалгаруулалтын дүнг танилцуулж, аймгийн ИТХ-

ын Тэргүүлэгчдийн 2020 оны 08 дугаар тогтоолоор 9 сумын 9 ахмадыг шалгарууллаа. Мөн соёл, урлагийн байгууллагуудын орлогыг үнэт цаасаар тооцох журмыг Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 16 дугаар тогтоолоор батлуулав.

Ерөнхий боловсролын 29 сургууль, 46 цэцэрлэгийн эрхлэгчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг аймгийн Засаг дарга баталсан.

Аймгийн мэргэжлийн боловсрол, сургалтын салбар зөвлөлийг хуралдуулж, 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилт болон 3 МСҮТ, 1 ПК-ын үйл ажиллагааны тайланг хэлэлцүүлж, 2020 оны төлөвлөгөөг батлууллаа.

**Боловсрол, соёл, урлагийн газрын үйлчилгээ:** Коронвирусын өвчлөл гарсантай холбогдуулан сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг зогсоож хөл хорио тогтоосон. БСШУСЯ болон аймгийн БСУГ-аас “Цахим хичээл-Төв аймаг” вэб сайтад нийт 83 хичээл байршуулан эцэг эх суралцагчдад хүргэлээ.

**Монгол туургатан театрын үйлчилгээ:**

**Музейн үйлчилгээ:**

**Нийтийн номын сангийн үйлчилгээ:**

**Биеийн тамир, спортын үйлчилгээ:**

**Гэр бүл, хүүхэд, залуучуудын үйлчилгээ:** Улсын онцгой комиссоос шинэ төрлийн корона вирусын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор бүх шатны сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг түр зогсоож, нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулахыг хориглосон шийдвэртэй холбогдуулан ГБХЗХГ-аас “Би-Хариуцлагатай аав, ээж” цахим сарын аяныг зарлаж, аяны хүрээнд 9 ажлыг төлөвлөн хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр олон нийтэд мэдээлэл, сурталчилгааг хүргэн ажиллаж байна. Энэ хүрээнд 02 дугаар сарын 29-ний өдрөөс 03 дугаар сарын 06-ны өдөр хүртэл “Үлгэрч аав ээж” цахим уралдааныг зарлаад байна.

Эрүүл мэндийн газартай хамтран “Халамжтай аав” сургалтыг 2020.02.14-ний өдөр Цагдаагийн газрын 40 албан хаагчдад зохион байгуулж “Жирэмсэн эхийн сэтгэл зүйн өөрчлөлт, Гэр бүл төлөвлөлт” сэдвээр сургалт, жирэмсэн үеийн биед үзүүлэх ачаалаллыг мэдрүүлэх тусгай хүндрүүлэгчтэй өмсгөлийг аав нарт өмсүүлж, өвдөлт мэдрүүлдэг аппарат ашиглан төрөх үеийн өвдөлтийг мэдрүүлэх туршилтыг хийсэн юм.

Аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо болон Аймгийн хүүхдийн төлөө зөвлөлүүдийн анхдугаар хуралдааныг 02 дугаар сарын 07, 10-ны өдрүүдэд зохион байгуулж 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцүүлж, 2020 оны ажлын төлөвлөгөөг батлуулав.

**Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээ:** 2020 оны 2-р сарын байдлаар 1750 иргэнд 645.5 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, 1091 иргэнд 194.0 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэмж, 279 иргэнд 93.4 сая төгрөгийн амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмж, 145 ахмад настанд 30.0 сая төгрөгийн тусламж хөнгөлөлт, 5149 ахмад настанд 417.9 сая төгрөгийн насны хишиг, 75 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 8.7 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж, хүнс тэжээлийн тусламж 312 өрхөд 40.8 сая төгрөг, жирэмсэн 812 эхэд 56.7 сая төгрөгийн тэтгэмж, алдар цолтой 59 ахмад настанд 19.4 сая төгрөг, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарсан 4415 эхэд 445.6 сая төгрөгийн тэтгэмж, алдарт эхийн 1, 2-р одонтой 8364 эхэд 937.3 сая төгрөг тус тус олгосон.

ӨМНС-н өргөдөлийн тоо-40. Шийдвэрлэсэн-31. Судалж шалгаж байгаа-9 өргөдөл байна. Шинэ төрсөн 159 хүүхдийн мэдээллийг бүртгэсэн. ӨМНСанд бүртгэлтэй 18508 өрхийн 30750 хүүхэд сар бүр хүүхдийн мөнгөн тэтгэмжийн үйлчилгээнд хамрагдаж 615.0 сая төгрөгийг олгов.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд боловсрол нийгмийн хамгааллын салбар комиссын хурлыг 2-р сард 2 удаа зохион байгуулж, ХБХ-үүдийг ирүүлэхгүйгээр 11 хүүхдийн байнгын асаргааны сунгалтыг хийлээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээлийг 1 аж ахуйн нэгж, 4 иргэнд нийт 3 ажлын байр шинээр бий болгож, 4 ажлын байрыг хадгалахад нь зориулж 50,0 сая төгрөгийн зээл олгов.

**Нийгмийн даатгалын үйлчилгээ:** Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс 3 удаа хуралдаж, нийт 179 иргэний асуудал хэлэлцсэнээс шинээр 45 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоож, 123 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг сунгаж, 11 иргэнийг цуцалсан.

Нийгмийн даатгалын тухай хуулиудад 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс орсон өөрчлөлтүүд болон Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх стандартын талаарх сургалтыг 5 байгууллагын 134 ажилтан, албан хаагчдад хийлээ.

“Цахим хяналтын веб программ” (<http://10.9.0.5/monitoring>) дахь нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, тайлан хүлээн авалт, тэтгэмжийн тогтоолт, олголттой холбоотой 3908 зөрчилтэй мэдээллийг гаргаж, хугацаатай албан шаардлага өгч үндэслэлийг шалгуулан зөрчлийг арилгуулав.

2020 оны 2 дугаар сарын байдлаар “Нийгмийн даатгалын тухай хууль”-д заасан болзол хангаж шинээр тэтгэвэр тогтоолгосон 308, шилжиж ирсэн 21, ажилласан жил нэмүүлэх, тэтгэврээ өөрчлөн тогтоолгосон 98, нийт 427 иргэний тэтгэврийн хувийн хэргийг шалгаж тэтгэвэр тогтоолоо.

Аймгийн хэмжээнд 14069 тэтгэвэр авагчдад 5.4 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгосон. Мөн 85 хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж 19.3 сая, жирэмсэн амаржсаны тэтгэмж 64 даатгуулагч 99.5 сая, ажилгүйдлийн тэтгэмж 18 даатгуулагчид 33.2 сая төгрөг, нийт 152.1 сая төгрөгийн тэтгэмж олгов.

**Эрүүл мэндийн үйлчилгээ:** Аймгийн Нэгдсэн эмнэлэгт 2020 оны 1 дүгээр сарын байдлаар 74 эх төрж, 74 нярай бүртгэгдсэн байна. 9271 иргэнд үзлэг хийж, үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 2527, амбулаторийн үзлэг 6199, идэвхитэй хяналтын үзлэг 545 байна. Түргэн тусламжийн дуудлагаар 750 иргэнд тусламж үйлчилгээ үзүүлсэн ба үүнээс алсын дуудлага 7 буюу 0.93%, осол гэмтлийн дуудлага 9 буюу 1.20%-ийг эзэлж байна. 655 өвчтөн 5138 ор хоног ашиглан хэвтэн эмчлүүлсэн ба дундаж ор хоног 7.8 байна.

Коронавирусын сэжигтэй 6 тохиолдолд хариу арга хэмжээ авч шинжилгээний сорьцыг ХӨСҮТ-д тээвэрлэн хүргэсэн. Бүх хариу сөрөг гарсан. Коронавирусын бэлэн байдлыг хангах, нөөц бүрдүүлэх хүрээнд ДЭМБ-аас 500 ширхэг маск, ЭМЯ-ны шуурхайн албанаас 1500 ширхэг гарын авлага, Засаг даргын нөөц хөрөнгөөс 11.4 сая төгрөгөөр нэг удаагийн хамгаалах өмсгөл, N95 амны хаалт 300 ширхэг, халуун хэмжигч 22 ширхэг, АНЭ-ийн тусгаарлах өрөөний вакуум хаалт зэргийг шийдвэрлэсэн. Нийгмийн хариуцлагын хүрээнд иргэн 2000 ширхэг Турк маск, санитол 100 ширхэг хандивласан бол аймгийн Мал эмнэлгийн газар хувийн хамгаалах хувцасны иж бүрдэл 20 ширхэг, 16л багтаамжтай цэнэглэдэг автомаск 1 ширхэг, хлорын шохой 50 кг, ариутгалын бодис 4 уут, 70% спирт 5 литр тус тус нийлүүлээ.

12 албан байгууллага, аж ахуй нэгжийн хүсэлтийн дагуу 15824 мкв талбайд, Цагаан баавгайт ХХК 80 аж ахуй нэгжийн 11110 мкв талбайд тус бүр халдваргүйтгэл хийсэн.

Аймгийн Онцгой комиссын шийдвэрээр 02 дугаар сарын 18-ны өдрөөс 27-ны өдөр хүртэл эрүүл мэндийн салбарын ажилтнууд жижүүрийн үүрэг гүйцэтгэж Өндөр дов, 4-р зөрлөгийн постоор нэвтэрч байгаа нийт 3043 автомашины 4563

хүний биеийн температурыг хэмжсэн. Сэжигтэй болон халуурсан тохиолдол бүртгэгдээгүй.

Улсын онцгой комиссын 02 дугаар тогтоолын дагуу аймгийн хэмжээнд 2 тусгаарлах байрны бэлэн байдлыг хангаж, 2020 оны 02 дугаар сарын 12-25-ны хооронд олон улсын нислэгээр ирсэн Төв аймгийн харъяат иргэдийг бүрэн ажиглалтад авч тандалт судалгаа хийн, утсаар заавар зөвлөмж өгч ажиллаж байна.

ЭМГазрын даргын баталсан удирдамжийн дагуу 2020 онд магадлан итгэмжлэлд хамрагдах Арга билэг сувилал, Баян СЭМТөвийн тусламж, үйлчилгээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж мэргэжил арга зүйгээр ханган зөвлөн тусаллаа.

“НҮЭМ, эх барих эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээний чиглэлээр 2020 онд хийх ажлыг хамтран төлөвлөх” хэлэлцүүлэг зохион байгуулахад 10 хүн оролцсон.

### **Зургаа. Санхүү, төрийн сангийн хэлтсийн хүрээнд:**

**Төсвийн орлого:** Орлогын төлөвлөгөө 1 дүгээр сарын байдлаар орон нутаг 310,8 сая төгрөг төвлөрүүлэхээс 351,1 сая төгрөг төвлөрүүлж 113,0 хувьтай, 40,3 сая төгрөгөөр буюу 13,0 хувиар давуулан биелүүлсэн. Аймгийн төвлөрсөн төсвийн орлого 1046,1 сая төгрөг төвлөрүүлэхээс 938,1 сая төгрөг төвлөрүүлж 89,7 хувьтай, 108,1 сая төгрөгөөр буюу 10,3 хувиар тасарсан. 3 шатны орлогын төлөвлөгөөний биелэлт нийт 148,4 сая төгрөгөөр давуулан биелүүлж, 109,7 %-тай байна. 3-н шатны орлогын төлөвлөгөөгөө биелүүлсэн 9 сум, 2 шатны төлөвлөгөө биелүүлсэн 13 сум, 1 шатны төлөвлөгөө биелүүлсэн 5 сум байна.

**Төсвийн зарлага санхүүжилт:** Сумдад эхний 01 сарын байдлаар нийт 2423,1 сая төгрөгийн зарлага санхүүжилтийг 27 сум, тэдгээрийн харьяа төсвийн байгууллагуудад олгосон.

*Салбараа авч үзвэл:*

Боловсрол,соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцаас 3302,1 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Үүнд:

-Ерөнхий боловсролын сургуулиудад 2220,0 сая төгрөг

-Хүүхдийн цэцэрлэгт 1082,1 сая төгрөг тус тус олгоод байна.

Эрүүл мэндийн сайдын багцаас 756,6 сая төгрөгийг олгосон.Үүнд:

-Сумдын эрүүл мэндийн төвд 718,1 сая төгрөг

-Өрхийн эмнэлэгт 38,5 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгов.

Газрын харилцаа,барилга хот байгуулалтын газарт 54,5 сая төгрөг, Хүүхэд гэр бүл, залуучуудын хөгжлийн газарт 28,4 сая төгрөгийн зарлага санхүүжилт тус тус олгоод байна.

Нийтийн ерөнхий үйлчилгээний салбарт 2423,1 сая төгрөгийн санхүүжилт олгосон.Үүнээс:

-Сумдын ИТХ,ЗДТГазар, Соёлын төвүүдийн санхүүжилтэд 1656,6 мянган төгрөг

-Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагуудад 766,5 мянган төгрөгийн санхүүжилт тус тус олгоод байна.

**Өр, авлага:** 2020 оны 1-р сарын байдлаар сумд, болон төсөвт байгууллагууд нийт 20413.0 мянган төгрөгийн авлага, 120269.9 мянган төгрөгийн өглөгтэй байна.

Нийт өглөгийн 38872.2 мянган төгрөг буюу 32.3 хувь нь түлш, халаалтын зардлын өглөг, 18401.3 мянган төгрөг буюу 15.3 хувь нь цалингийн өглөг, 20876.7 мянган төгрөг буюу 17.4 хувь нь НДШимтгэлийн өр, 6632.7 мянган төгрөг буюу 5.5 хувь нь гэрэл цахилгааны зардлын өгрлөг, 16090.0 мянган төгрөг буюу 13.4 хувь эмийн зардлын өглөг, үлдсэн 19397,0 мянган төгрөг буюу 16.1 хувийг бусад өр эзэлж байна.

### **Долоо. Хяналт-шинжилгээ, дотоод аудитын хэлтсийн хүрээнд:**

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 112 зорилтын 378 арга хэмжээ, аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайланг хэлэлцүүлж, дүнг 94.28%-тай баталгаажуулав. Үүнээс 100%-307, 70%-61, 40%-5, үнэлэх боломжгүй-5 заалт байна. Урьд оноос 7.51 пунктээр өслөө.

Аймгийн эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл 6 салбарын 97 зорилт, 287 арга хэмжээний хэрэгжилт **93.93** хувьтай, үүнээс 100%-228, 70%- 42, 40%- 7, үнэлэх боломжгүй 10 арга хэмжээ тус тус хэрэгжсэн.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааны 15 тэмдэглэлийн 81 заалтад ХШҮ-хийж Засаг даргын зөвлөлийн хурал, ИТХТ-ийн III хуралдаанаар хэлэлцүүлэхэд **91.60%**- тай дүгнэгдлээ.

Төв аймгийн Онцгой байдлын газарт ISO 9001:2015 олон улсын стандарт нэвтрүүлэх чиглэлээр 20 орчим албан хаагчдад сургалт зохион байгуулав. Мөн гүйцэтгэлийн төлөвлөгөөг цахимд нэвтрүүлэх ажлын хүрээнд 200 гаруй хууль, 100 орчим үндэсний болон дэд хөтөлбөрийг мэдээллийн санд оруулсан.

**Санхүүгийн хяналтын чиглэлээр:** 2020 оны төлөвлөгөөний дагуу Төсвийн тухай хуулийн хэрэгжилт, төсвийн хөрөнгийн зарцуулалтад сумдын Сум хөгжүүлэх сан, Эргэлтийн эмийн сан, Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 он, Баянчандмань сумын политехникийн коллеж, Эрдэнэ сумын МСҮТ, Зуунмод сумын МСҮТ, Сүмбэр, Жаргалант сумын төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 89666.4 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 26061.9 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн акт, 63604.5 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн албан шаардлага тогтоов.